

ЭРДЭМТДИЙН ОЙ

АКАДЕМИЧ Ш. НАЦАГДОРЖ

70 насны нь ойд

Академич Ш. Нацагдорж бол тус улсад марксист түүхийн шинжлэх ухааныг үүсгэн хөгжүүлэх үйлст үлэмжхэн үүрэг гүйцэтгэсэн ахмад түүхч шинжлэх ухааны томоохон зүтгэлтэн билээ. Ш. Нацагдорж 1935 онд 17 настайдаа Шинжлэх ухааны хүрээлэнгийн түүхийн тасагт дагалдан сургагчаар орж Монголын түүх судлалын босгыг анх алхжээ.

Ш. Нацагдоржийн эрдэм шинжилгээний анхны бүтээл нь 1938 онд «Шинэ толь» сэтгүүлд хэвлэгдсэн «Монголын хувьсгалын удирдагч гавьяат нөхөр Сүхбаатарын товч түүх» хэмээх өгүүлэл бөгөөд түүнийг дэлгэрүүлэн «Сүхбаатарын намтар» хэмээх нэгэн сэдэвт зохиолыг бичиж 1943 онд нийтлүүлжээ. Эл зохиол нь манай нам ард түмний гарамгай удирдагч Дамдингийн Сүхбаатарын хувьсгалт үйл ажиллагааг МАХН, ардын хувьсгалын түүхтэй нягт холбон харуулж Сүхбаатар судлалын эхийг тавьсан дорвитой бүтээл болсон тул 1947 онд төрийн шагнал хүртээжээ.

Тэр үеэс Монголын ард түмний түүхийг Ш. Нацагдорж өргөн цар хүрээтэй судалж эхэлжээ. Тэр тавь гаруй жилийн турш тус улсын түүхийг судлахдаа ардын хувьсгалын түүхийг анхаарлынхаа төвд байлгаж «МАХН-ын товч түүх» хамтын бүтээлийг туурвихад зохиогчоор оролцжээ. Ш. Нацагдорж хувьсгалын үеийн монголын түүхийн шинжлэх ухааны гол үр дүн болсон «БНМАУ-ын түүх» зохиолыг анх зохиохоос эхлэн хэд хэдэн удаа нэмэн засварлаж редакторлахад оролцсон юм. Тэр мөн «Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх», «БНМАУ-ын соёлын түүх», «БНМАУ-ын нийгмийн бүтэц» зэрэг хамтын бүтээл туурвих ажлыг зохион байгуулж удирдахын хамт өөрөө зохиогчоор оролцон редакторлах ажлыг гүйцэтгэжээ.

Ш. Нацагдорж, ардын хувьсгалын үеийн түүхийг судлах талаар идэвхтэй ажиллахын зэрэгцээ судалгааны гол ажлаа Монголын дундад зууны үеийн түүхэнд зориулсан юм. Монголын түүхийн харьцангуй бага судлагдсан чухал сэдвийн нэг болох феодализмын асуудлыг сонгон авч түүний үүсэл, хөгжил, төгсгөлийн зангилгаа асуудлыг судлан боловсруулсан олон бүтээл туурвисны дотор «Монголын феодализмын үндсэн замнал» (УБ., 1978) нэгэн сэдэвт зохиол чухал байр эзэлдэг юм.

Уг зохиолд нүүдлийн феодализмын ерөнхий шинж чанар болон монголын феодализмын онцлог түүний Монголын нийгмийн нийгэм-эдийн засгийн хөгжилд үзүүлсэн нөлөө тусгал, хөгжлийн үе шат зэрэг онолын гол асуудлуудыг гүнзгийрүүлэн судалж өмнөх маргаантай олон асуудалд зохих хариу өгчээ.

Академич Ш. Нацагдоржийн Монголын феодализмын асуудлаар дэвшүүлсэн онолын нэг чухал дүгнэлт нь нүүдлийн болон суурьшмал орны феодализм нь зарчмын ялгаагүй бөгөөд нүүдэлчдийн үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл нь газар, түүнд түшиглэсэн мал хоёр байдгийг тодорхой харуулжээ.

Академич Ш. Нацагдоржийн гол томхон бүтээлийн нэг «Халхын түүх» гэдэг зохиолд XVII—XX зууны эхэн үеийн Ар Монголын түүхийг нийтэд нь улируулан үзэж эрдэм шинжилгээний чухал чухал санаа дүгнэлтүүдийг дэвшүүлэн тавьжээ. «Халхын түүх» зохиолд манжийн эрхшээлд байсан халх монголын нийгмийн үйлдвэрлэх хүчин, үйлдвэрлэлийн харилцааны хөгжил, хөдөлмөрчин ард түмний түүхэн дэх роль, ангийн тогтолцоо, бүтэц, феодалын мөлжлөгийн олон хэлбэр зэрэг өргөн хүрээтэй асуудлыг судлан шинжилснээрээ гагцхүү улс төрийн түүхийг судалсан урьд үеийн түүхчдээс эрс ялгаатай болсон юм.

Академич Ш.Нацагдорж монголын түүхийн хувьсгалын өмнөх архивын материалд тулгуурлан «То ван ба түүний сургаал» (УБ., 1969), «Сүм, хамжлага, шавь, ард» (УБ., 1972) зэрэг судалгааны чухал бүтээлүүд туурвиж Ц. Насанбалжирын хамт «Ардын заргын бичиг» (УБ., 1960), «Дөрвөн аймгийн алба тэгшитгэсэн данс» (УБ., 1961) зэрэг чухал баримт бичгүүдийг боловсруулж нийтлүүлсэн нь монголын түүхийн үнэт сурвалж бичиг, судалгааны зохиол болж байна. Мөн ийм бүтээлийн нэгэнд түүний бичсэн «Ховд хязгаарт ард Аюушийн удирдлагын дор гарсан ардын хөдөлгөөн» зэрэг хэд хэдэн нэгэн сэдэвт зохиол зүй ёсоор багтана.

Академич Ш.Нацагдоржийн «Халх дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн», «Д. Сүхбаатарын намтар» зэрэг бүтээлүүд орос, англи, япон хэлээр орчуулагджээ.

Ш. Нацагдорж монголын түүхийн сурвалж бичигт ихээхэн анхаарал тавьж «Улаан хацарт», «Харьяат хошууны дотор дагаж явуулахаар тогтоож тушаасан ухуулах бичгийн уг эх» мэтийн зохиолд оршил, удиртгал бичиж, тайлбар зүүлт хийж хэвлүүлж, «Монгол ардын журамт цэргийн дурдатгалууд» 4 боть, «Д. Сүхбаатарын үйл амьдралтай холбогдох баримт материалын эмхэтгэл», «Хувьсгалын өмнөх Монгол дахь газрын харилцаа» гэх зэрэг архивын баримт бичгийн эмхэтгэлийг редакторлаж олны хүртээл болгох үйлсэд их хандив оруулжээ.

Ш. Нацагдорж эрдэм шинжилгээний ажлын зэрэгцээ бас үндэсний соёлын өвийг хамгаалан хөгжүүлэх, шинжлэх ухааны мэдлэгийг олон түмэнд түгээх явдалд ихээхэн зүтгэсэн нэрт зохиолч, сурган хүмүүжүүлэгч МУИС-ийн ахмад профессоруудын нэг юм.

Ш. Нацагдорж бол нийгмийн нэрт зүтгэлтэн бөгөөд 1951 онд Ардын Их Хурлын депутатад сонгогдсон ба МАХН-ын хэд хэдэн их хуралд төлөөлөгчөөр оролцжээ. Ш. Нацагдорж Монголын Энх тайвны хороо, МЗЭ-ийн хорооны гишүүн, Монгол-Английн Найрамдлын нийгэмлэгийн дарга, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн хүн юм. Тэр «Монголын түүхчдийн үндэсний холбоо»-г анх байгуулагдахаас эхлэн одоо хүртэл толгойлж Монголын түүхчдийн олон улсын хэлхээ холбоог бэхжүүлэх, тэдний бүтээлийг гадаадад сурталчлах үйлсэд идэвхтэй оролцож байна.

Ш. Нацагдорж эрдэм шинжилгээ, сурган хүмүүжүүлэх, уран зохиолын ажлыг хослуулан хийж монголчуудын нийгмийн сэтгэлгээний хөгжилтөнд үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд нам засгаас түүний хувь гавьяа зүтгэлийг өндрөөр үнэлж Төрийн шагнал хүртээн, Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одон, Хөдөлмөрийн ба бусад медалиар хөхүүлэн шагнажээ.

Академич, профессор Ш. Нацагдорж таны 70 насны ирмүүн бүтээлч энэ ойг тохиолдуулан Дорнодахины судлалын хүрээлэнгийн хамт олон, тус сэтгүүлийн редакцийн зөвлөл чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж эрдэм судлалын нөр их үйлсэд чинь улам их амжилт хүсч байна.

ШУА-ИЙН СУРВАЛЖЛАГЧ ГИШҮҮН

Н. ИШЖАМЦЫН 60 НАС

1988 оны тавдугаар сарын 5-нд манай нэрт түүхч, ШУА-ийн сурвалжлагч гишүүн, түүхийн ухааны доктор Нямбуугийн Ишжамц 60 нас хүрлээ. Манай улсын шинжлэх ухааны хүрээлэн (тэр үеийн нэр)-гийн түүхийн тасаг 1953 онд нэгэн авьяаслаг залуу судлаачаар нэмэгдсэн нь тэр жил Москвагийн Улсын Их сургуулийн түүхийн ангийг төгсгөж ирсэн ирээдүйн эрдэмтэн Н. Ишжамц байлаа.

Тийнхүү Н. Ишжамц эрдэм судалгааны ажилд авьяас билгээ зориулж ШУА-д тасралтгүй ажилласан 35 дахь жил дээрээ 60 насныхаа ойтой золгож байна. Сурах, хөдөлмөрлөх хоёрыг байнга хослуулж ирсэн нь Н. Ишжамцын эрдмийн үйл ажиллагааны нэг онцлог юм. Тэрээр 1957-1960 онд Бээжингийн их сургуулийн аспирантурт суралцаж төгсөөд тус Академийн түүхийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажилласан бол 1972 онд Москвад түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж ирээд тэр үед шинэ тулгар байгуулагдсан ШУА-ийн Ази, Африкийн хэлтсийн дарга, Дорнодахины судлалын хүрээлэнгийн орлогч захирал, захирлаар 1988 оны 9-р сар буюу 60 насныхаа өндөрлөгийг давтал хүчин зүтгэж одоо мөн хүрээлэндээ эрдэм шинжилгээний ахлах ажилтнаар ажиллаж байна.

1982 онд ШУА-ийн сурвалжлагч гишүүнээр сонгогдсон д-р Н. Ишжамц 1960— 1970-аад онд судалгаа шинжилгээнийхээ ажлыг Монголын түүхийн харьцангуй бага судлагдаж, «цагаан толбо» болж байсан дундад зууны үеийн үндэсний эрх чөлөөний тэмцэл хөдөлгөөн, Монголын төрт ёсны үүсэл хөгжил, монголчуудын угсаа язгуур, үндэстэн бүрэлдсэн түүх, түүнчлэн Төв Азийн нүүдэлчдийн түүх соёл зэрэг сэдвүүдээр ажиллаж олон тооны бүтээл туурвиснаараа эх орны түүхийн шинжлэх ухаанд чамлашгүй хувь нэмэр оруулсан юм. Түүний бичсэн «Амарсанаа, Чингүнжав нарын бослого» (1962), «Монголын феодалын нэгдсэн төр байгуулагдсан нь» (1972) зэрэг эрдэм шинжилгээний арга зүйн өндөр түвшинд бичигдсэн нэгэн сэдэвт, даацтай бүтээлүүд нь Монголын түүхийн ном зүйн сан хөмрөгт зүй ёсоор хүндтэй байр эзэлдэг юм.

Сурвалжлагч гишүүн Н. Ишжамц 80-аад оны судалгаагаа хятад, дорнодахины судлалд голлон чиглүүлж монголын түүхийн зангилаа асуудлаар байнга ажиллахын зэрэгцээ Хятадын түүхийн нэн эртнээс эхлэн өнөө хүртэлх тоймыг харуулсан «Балар эртний хятадын түүхийн зарим асуудал», «Эзэн боолын нийгэмлэгт эртний хятад улс», «Феодалын хятад улс», «Хятадын хөрөнгөтөн-газрын эздийн Бүгд Найрамдах Улс»,